

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/025/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
www.audit.mn  
Алтай хот  
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа  
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn  
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг  
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn  
Ахлах аудитор: Д.Цэрэнханд  
Утас: 99086381 Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn  
Аудитор: Э.Сүнжидмаа  
Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2024/123/НА-СТА-ТШЗ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02.23 № 73

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЕСӨНБУЛАГ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Ж.БАТЦЭЦЭГ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, 22 дугаар зүйлийн 12.1, 20 дугаар зүйлийн 20.2.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, өрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын үнэлгээ хуваарилалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Амралын цалинг давхардуулан 1,350.1 мянган төгрөгийг илүү тооцон олгосон,
- Босго үнээс давсан 183,501.4 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй,

8225020183

- Дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүйгээр албан хаагчдад цалингийн төсвөөс хэмнэгдсэн 59,129.0 мянган төгрөгийг урамшуулал хэлбэрээр олгосон,
- Цалингийн зардлын дүн, нийгмийн даатгалын тайлангийн дүнгээс 2,147.2 мянган төгрөгөөр зөрүүтэй,
- Хөрөнгийн хэсэгчилсэн тооллогоор байгууллагын дансанд бүртгэлтэй 521 ширхэг 477,636.4 мянган төгрөгийн хөрөнгийг бусад байгууллагад ашиглуулсан, 4,700.0 мянган төгрөгийн 50 толгой мал биетээр байхгүй,
- Тушаал шийдвэргүйгээр 4,326.0 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон,
- Цалингийн зардлын төсвөөс 1,164.8 мянган төгрөгийн шагнал олгосон,
- Үр дүнгийн урамшуулалд 382.0 мянган төгрөгийг дутуу тооцож олгосон,
- Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын аварга малчдын бэлэг дурсгал шагналд 18,609.5 мянган төгрөгийг, хамт олон, иргэн, байгууллагад 34,182.9 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн, сургалтын хоолны зардалд 38,725.0 мянган төгрөгийг, уралдаан тэмцээний зардалд 8,204.0 мянган төгрөгийг, золголтын зардалд 600.0 мянган төгрөг, спортын амжилт гаргасан иргэнд 5,000.0 мянган төгрөгийг, боловсролын чанарын хөтөлбөрийн хүрээнд гадаад улсад туршлага судлахад 15,000.0 мянган төгрөг, иргэдийн төлөөлөгч нарт олгосон гарын бэлэг дурсгалын зүйлд 8,890.0 мянган төгрөг, баяр наадмын зардалд 2,089.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан,
- Санхүүгийн тайлангаарх 99,337.7 мянган төгрөгийн авлага, 4,106.7 мянган төгрөгийн өглөгийг барагдуулаагүй,
- Эрүүл хот чадавхжуулах ТББ-аас ирүүлсэн урилгын дагуу БНСУ-д дэлхийн хотын чуулга уулзалтад оролцож 11,500.0 мянган төгрөгийг, хотын дарга нар чуулга уулзалтад оролцоход 5,847.1 мянган төгрөгийн замын зардал, гадаад албан томилолтыг төсвөөс зарцуулсан,
- Жинст багийн хөгжил хорооллын халаалтын шугамын засварын ажлын төлбөрт 81 айл өрхөд 39,690.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосон байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж Улаанбаатар хотод нарийн мэргэжлийн эмнэлгийн үзлэг оношилгоонд хамруулсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

- Тайлант онд төсвийн хөрөнгөөр 542,402.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй 369,858.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан байна.
- Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас бэлэг дурсгал, шагнал, сургалтын хоолны зардал, хамт олон, иргэн, байгууллага дэмжлэгт нийт 131,301.2 мянган төгрөгийн зарцуулсан байна.
- Нийт 183,501.4 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагаа зарлаагүй байна.
- Гадаад албан томилолт, иргэдэд олгосон дэмжлэгт нийт 32,347.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### **Бусад асуудал**

Тайлант онд 1 хөтөлбөр, 5 зорилт, 117 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас, 94.1 хувиар Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГҮНЖИДМАА



Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>230,660,295.62</b>	<b>547,174,145.62</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>138,008,079.83</b>	<b>338,979,929.83</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,063,068.83	3,082,568.83
33300	Татаас, санхүүжилтийн авлага	9,945,909.00	9,489,910.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>125,999,102.00</b>	<b>326,407,451.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	67,864,711.00	222,342,651.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	58,134,391.00	104,064,800.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>92,652,215.79</b>	<b>188,294,215.79</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>45,352,215.79</b>	<b>140,994,215.79</b>
35410	Бичиг хэргийн материал	2,650,510.00	3,400,510.00
35420	Аж ахуйн материал	36,826,705.79	36,908,705.79
35450	Барилгын засварын материал	4,010,000.00	7,330,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,865,000.00	93,355,000.00
35600	Мал амьтад	47,300,000.00	47,300,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	<b>19,900,000.00</b>
36300	Тэжээлийн нөөц	-	19,900,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,567,591,397.76</b>	<b>2,072,990,326.45</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,567,591,397.76</b>	<b>2,072,990,326.45</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,456,937,897.52</b>	<b>1,983,768,326.45</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,118,953,491.87	760,691,618.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	(428,870,821.58)	(198,087,944.06)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	108,054,800.00	421,713,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(96,554,800.12)	(101,554,800.16)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,043,411,181.90	1,243,148,191.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(581,907,586.58)	(679,318,202.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,423,990.00	116,300,150.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(67,910,202.08)	(66,792,450.61)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,000,000.00	10,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	403,064,661.00	850,186,210.16
39215	Хуримтлагдсан элэгдэл	(144,726,816.89)	(372,518,246.74)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>110,653,500.24</b>	<b>89,222,000.00</b>
39301	Програм хангамж	2,640,000.00	2,640,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,139,999.76)	(2,640,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	110,153,500.00	89,222,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,798,251,693.38</b>	<b>2,620,164,472.07</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,106,700.00</b>	<b>4,106,700.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,106,700.00</b>	<b>4,106,700.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>4,106,700.00</b>	<b>4,106,700.00</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>4,106,700.00</b>	<b>4,106,700.00</b>
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	4,106,700.00	4,106,700.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,794,144,993.38</b>	<b>2,616,057,772.07</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,794,144,993.38</b>	<b>2,616,057,772.07</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	379,938,538.67	379,938,538.67
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	379,938,538.67	379,938,538.67
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>566,473,387.05</b>	<b>1,572,955,675.20</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	634,071,419.40	793,498,656.51
51220	Тайлант үеийн үр дүн	(67,598,032.35)	779,457,018.69

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	847,733,067.66	663,163,558.20
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,798,251,693.38</b>	<b>2,620,164,472.07</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**(төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,793,390,340.00</b>	<b>6,266,569,201.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>84,059,255.00</b>	<b>460,170,075.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>84,059,255.00</b>	<b>460,170,075.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	84,059,255.00	369,858,075.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	90,312,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,709,331,085.00</b>	<b>5,806,399,126.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>428,906,931.00</b>	<b>144,261,926.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	15,000,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	165,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	263,906,931.00	112,296,426.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	16,965,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>3,280,424,154.00</b>	<b>5,662,137,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,280,424,154.00	5,662,137,200.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,860,988,372.35</b>	<b>5,209,763,344.39</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,860,988,372.35</b>	<b>5,209,763,344.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,760,287,513.21</b>	<b>4,973,186,828.72</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>767,664,327.95</b>	<b>1,544,054,627.21</b>
210101	Үндсэн цалин	491,524,479.77	933,238,088.42
210102	Нэмэгдэл	150,001,109.62	401,399,959.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	64,360,649.12	80,421,111.06
210104	Урамшуулал	61,778,089.44	128,995,468.01
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>105,942,387.30</b>	<b>169,347,188.46</b>
210201	Тэтгэврийн даатгал	83,518,433.67	127,279,691.66

Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	5,459,029.25	11,705,824.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,093,859.96	4,252,612.10
210204	Ажилгүйдлийн даатгал	1,012,005.81	4,502,612.10
210205	Эрүүл мэндийн даатгал	10,859,058.61	21,606,448.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>87,393,912.72</b>	<b>94,418,911.55</b>
210301	Гэрэл, цахилгаан	13,387,986.87	13,719,828.09
210302	Түлш, халаалт	63,302,789.85	70,989,427.46
210303	Цэвэр, бохир ус	10,703,136.00	9,709,656.00
210304	Байрны түрээс	-	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>71,937,954.10</b>	<b>65,477,974.02</b>
210401	Бичиг хэрэг	9,368,350.00	9,909,400.00
210402	Тээвэр, шатахуун	38,581,000.00	42,772,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,774,754.10	8,423,966.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,493,850.00	3,652,508.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>71,012,205.00</b>	<b>33,818,892.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	220,000.00	-
210604	Урсгал засвар	70,792,205.00	33,818,892.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>12,468,950.00</b>	<b>26,825,150.00</b>
210702	Дотоод албан томилолт	12,468,950.00	26,825,150.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>138,681,057.00</b>	<b>200,078,603.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	135,167,900.00	197,201,034.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,498,025.00	64,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	340,232.00	414,232.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	208,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	466,900.00	1,972,900.00
210807	Газрын төлбөр	1,000,000.00	403,937.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,505,186,719.14</b>	<b>2,839,165,482.48</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,259,429,720.79	2,528,868,224.09
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	24,914,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	240,756,998.35	285,382,858.39
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>100,700,859.14</b>	<b>236,576,515.67</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>97,593,646.00</b>	<b>94,423,288.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	58,353,288.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	97,593,646.00	36,070,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,107,213.14</b>	<b>142,153,227.67</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,107,213.14	142,153,227.67
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(67,598,032.35)</b>	<b>1,056,805,856.61</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>277,348,837.92</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	182,360,437.92
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	94,988,400.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(67,598,032.35)</b>	<b>779,457,018.69</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,709,331,085.00</b>	<b>5,857,643,837.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,709,331,085.00</b>	<b>5,857,643,837.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>428,906,931.00</b>	<b>195,506,637.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	15,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	165,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	163,541,137.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	263,906,931.00	16,965,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>3,280,424,154.00</b>	<b>5,662,137,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,280,424,154.00	5,662,137,200.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,464,244,918.00</b>	<b>5,021,845,451.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,464,244,918.00</b>	<b>5,021,845,451.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,312,299,347.86</b>	<b>4,765,853,470.33</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>769,522,030.72</b>	<b>1,545,074,127.21</b>
210101	Үндсэн цалин	455,373,320.02	934,257,588.42
210102	Нэмэгдэл	153,278,490.97	401,399,959.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	71,681,328.60	80,421,111.06
210104	Урамшуулал	89,188,891.13	128,995,468.01

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>104,084,684.53</b>	<b>169,347,188.46</b>
210201	Тэтгэврийн даатгал	86,996,684.53	127,279,691.66
210202	Тэтгэмжийн даатгал	4,280,000.00	11,705,824.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,410,000.00	4,252,612.10
210204	Ажилгүйдлийн даатгал	825,000.00	4,502,612.10
210205	Эрүүл мэндийн даатгал	8,573,000.00	21,606,448.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>87,393,912.72</b>	<b>94,418,911.55</b>
210301	Гэрэл, цахилгаан	13,387,986.87	13,719,828.09
210302	Түлш, халаалт	63,302,789.85	70,989,427.46
210303	Цэвэр, бохир ус	10,703,136.00	9,709,656.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>68,057,954.10</b>	<b>67,659,274.02</b>
210401	Бичиг хэрэг	9,047,150.00	10,820,400.00
210402	Тээвэр, шатахуун	38,581,000.00	42,483,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,774,754.10	8,643,966.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,935,050.00	4,991,808.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>75,481,205.00</b>	<b>43,494,892.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,489,000.00	-
210604	Урсгал засвар	73,992,205.00	43,494,892.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>12,468,950.00</b>	<b>26,825,150.00</b>
210702	Дотоод албан томилолт	12,468,950.00	26,825,150.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>130,846,057.00</b>	<b>266,978,603.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	127,332,900.00	264,101,034.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,498,025.00	64,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	340,232.00	414,232.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	208,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	466,900.00	1,972,900.00
210807	Газрын төлбөр	1,000,000.00	403,937.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,064,444,553.79</b>	<b>2,552,055,324.09</b>

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,059,444,553.79	2,527,140,924.09
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	24,914,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>151,945,570.14</b>	<b>255,991,980.67</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>97,593,646.00</b>	<b>94,423,288.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	58,353,288.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	97,593,646.00	36,070,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>54,351,924.14</b>	<b>161,568,692.67</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,107,213.14	142,153,227.67
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	51,244,711.00	19,415,465.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>245,086,167.00</b>	<b>835,798,386.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>245,086,167.00</b>	<b>835,798,386.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>245,086,167.00</b>	<b>835,798,386.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>245,086,167.00</b>	<b>835,798,386.00</b>
223001	Бусад хөрөнгө	208,590,167.00	715,201,986.00
224001	Стратегийн нөөц хөрөнгө	-	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	36,496,000.00	120,596,400.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(245,086,167.00)</b>	<b>(835,798,386.00)</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	379,938,538.67	847,733,067.66	634,071,419.40	1,861,743,025.73
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	379,938,538.67	847,733,067.66	634,071,419.40	1,861,743,025.73
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-67,598,032.35	-67,598,032.35
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	379,938,538.67	847,733,067.66	566,473,387.05	1,794,144,993.38
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	379,938,538.67	847,733,067.66	566,473,387.05	1,794,144,993.38

Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	227,025,269.46	227,025,269.46
13	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>379,938,538.67</b>	<b>847,733,067.66</b>	<b>793,498,656.51</b>	<b>2,021,170,262.84</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	- 184,569,509.46	0.00	-184,569,509.46
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	779,457,018.69	779,457,018.69
20	<b>2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>379,938,538.67</b>	<b>663,163,558.20</b>	<b>1,572,955,675.20</b>	<b>2,616,057,772.07</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан-Орон нутгийн төсөв (төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>10,273,022,200.00</b>	<b>5,500,568,507.33</b>	4,772,453,692.67	53.5
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,523,022,200.00</b>	<b>4,860,276,758.33</b>	4,662,745,441.67	51.0
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,816,695,200.00</b>	<b>4,765,853,470.33</b>	50,841,729.67	98.9
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,607,000,000.00</b>	<b>1,545,074,127.21</b>	61,925,872.79	96.1
210101	Үндсэн цалин	837,000,000.00	934,257,588.42	(97,257,588.42)	111.6
210102	Нэмэгдэл	770,000,000.00	401,399,959.72	368,600,040.28	52.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	80,421,111.06	(80,421,111.06)	
210104	Урамшуулал	0.00	128,995,468.01	(128,995,468.01)	
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>205,250,000.00</b>	<b>169,347,188.46</b>	35,902,811.54	82.5
210201	Тэтгэврийн даатгал	161,970,000.00	127,279,691.66	34,690,308.34	78.6
210202	Тэтгэмжийн даатгал	10,820,000.00	11,705,824.20	(885,824.20)	108.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,410,000.00	4,252,612.10	1,157,387.90	78.6
210204	Ажилгүйдлийн даатгал	5,410,000.00	4,502,612.10	907,387.90	83.2
210205	Эрүүл мэндийн даатгал	21,640,000.00	21,606,448.40	33,551.60	99.8
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>96,961,000.00</b>	<b>94,418,911.55</b>	2,542,088.45	97.4
210301	Гэрэл, цахилгаан	15,000,000.00	13,719,828.09	1,280,171.91	91.5
210302	Түлш, халаалт	71,961,000.00	70,989,427.46	971,572.54	98.6
210303	Цэвэр, бохир ус	10,000,000.00	9,709,656.00	290,344.00	97.1

Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>67,671,800.00</b>	<b>67,659,274.02</b>	12,525.98	100.0
210401	Бичиг хэрэг	10,651,800.00	10,820,400.00	(168,600.00)	101.6
210402	Тээвэр, шатахуун	45,000,000.00	42,483,100.00	2,516,900.00	94.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,920,000.00	8,643,966.02	(723,966.02)	109.1
210404	Ном, хэвлэл	500,000.00	0.00	500,000.00	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	720,000.00	(620,000.000)	720.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,000.00	4,991,808.00	(1,491,808.000)	142.6
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>161,600,000.00</b>	<b>43,494,892.00</b>	118,105,108.00	26.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	84,100,000.00	0.00	84,100,000.00	0.0
210602	Тавилга	22,900,000.00	0.00	22,900,000.00	0.0
210604	Урсгал засвар	54,600,000.00	43,494,892.00	11,105,108.00	79.7
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>29,351,200.00</b>	<b>26,825,150.00</b>	2,526,050.00	91.4
210702	Дотоод албан томилолт	29,351,200.00	26,825,150.00	2,526,050.00	91.4
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>260,461,200.00</b>	<b>266,978,603.00</b>	(6,517,403.00)	102.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	257,386,200.00	264,101,034.00	(6,714,834.00)	102.6
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	64,500.00	35,500.00	64.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	415,000.00	414,232.00	768.00	99.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	22,000.00	38,000.00	36.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	1,972,900.00	27,100.00	98.6
210807	Газрын төлбөр	500,000.00	403,937.00	96,063.00	80.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,388,400,000.00</b>	<b>2,552,055,324.09</b>	(63,655,324.09)	106.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,363,400,000.00	2,527,140,924.09	(163,740,924.090)	106.9

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,000,000.00	24,914,400.00	85,600.00	99.7
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,706,327,000.00</b>	<b>94,423,288.00</b>	4,611,903,712.00	2.0
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>4,610,885,000.00</b>	<b>0.00</b>	4,610,885,000.00	0.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	4,610,885,000.00	0.00	4,610,885,000.00	0.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>95,442,000.00</b>	<b>94,423,288.00</b>	1,018,712.00	98.9
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	59,042,000.00	58,353,288.00	688,712.00	98.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,400,000.00	36,070,000.00	330,000.00	99.1
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>750,000,000.00</b>	<b>640,291,749.00</b>	109,708,251.00	85.4
223001	Бусад хөрөнгө	750,000,000.00	640,291,749.00	109,708,251.00	85.4
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>10,273,022,200.00</b>	<b>5,662,137,200.00</b>	4,610,885,000.00	55.1
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>10,273,022,200.00</b>	<b>5,662,137,200.00</b>	4,610,885,000.00	55.1
320001	Орон нутгийн төсвөөс	10,273,022,200.00	5,662,137,200.00	4,610,885,000.00	55.1

## 2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>195,506,637.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>195,506,637.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	176,091,172.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	166,091,172.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	166,091,172.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	19,415,465.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	19,415,465.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	195,506,637.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	195,506,637.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	145,995,228.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,511,409.00

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 490,379.9 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

### Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Төвлөрүүлэх шилжүүлгийн эдийн засгийн ангилал 242,153.2 мянган төгрөгийг зөрүүтэй,
- Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 1,019.5 мянган төгрөгийн дутуу,
- Гэрээгээр гүйцэтгэсэн газрын хянан баталгааны ажлыг нягтлан бодох бүртгэлд орлогод тусгаагүй,
- Хөрөнгө оруулалтаар хийсэн 7 төсөл, арга хэмжээний 219,207.2 мянган санхүүжилтийг урьдчилж төлсөн авлагаар тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна

Залруулагдаагүй нийт 922,675.2 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон нь ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 922,675.2 мянган төгрөгийн 15 зөрчил<sup>2</sup> илэрч 32,411.9 мянган төгрөгийн төлбөрийн акт, 888,116.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 1 заалттай 2,147.2 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

1. Амралын цалинг давхардуулан 1,350.1 мянган төгрөгийг илүү тооцон олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-т "Ээлжийн амралтын цалинг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлснөөс тооцож олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/19 дүгээр тушаалын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.4-т "Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Амралт цалин давхардуулан олгосон мөнгийг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон

2. Байгууллагын дансанд бүртгэлтэй 620.0 толгой малаас 2 иргэнтэй холбоотой 50 толгой 4,700.0 мянган төгрөгийн мал нь бодитоор байхгүй дутагдсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутагдсан малыг байгууллагын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3. Үр дүнгийн урамшууллыг 2 ажилтанд 382.0 мянган төгрөгийг дутуу тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2.2-т "төсвийн шууд

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид", 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагч нарт буцаан олгох төлбөрийн акт тогтоосон.

4. Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд гадаад туршлага судлахад 15,000.0 мянган төгрөг, сумын хурлын төлөөлөгч нарт урамшуулал гарын бэлэг дурсгалын зүйлд 8,890.0 мянган төгрөг, баяр наадам зардалд 2,089.8 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон

## 5.2 Албан шаардлага

1. Босго үнээс давсан 183,501.4 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Босго үнээс давсан бараа, ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Байгууллагын албан хаагчдад цалингийн төсвөөс хэмнэгдсэн 59,129.0 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүйгээр урамшуулал хэлбэрээр олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг арилгаж цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн

3. Хөрөнгийн хэсэгчилсэн тооллогоор байгууллагын дансанд бүртгэлтэй 521 ширхэг 477,636.4 мянган төгрөгийн хөрөнгийг бусад байгууллагад ашиглуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн

4. Цалингийн зардлын төсвөөс 1,164.8 мянган төгрөгийн шагнал олгосон Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 190 дүгээр тогтоол-д заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

5. Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын аварга малчдын бэлэг дурсгал шагналд 18,609.5 мянган төгрөгийг, хамт олон иргэн байгууллагад 34,182.9 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн, сургалт хоолны зардал 38,725.0 мянган төгрөгийг, уралдаан тэмцээний зардалд 8,204.0 мянган төгрөгийг зарцуулсан, золголтын зардал 600.0 мянган төгрөг, спортын амжилт гаргасан иргэн 5000.0 мянган төгрөг тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хэвсгалын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэлт: Төсвийг үр ашигтай, арилан хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлсэн

6. Санхүүгийн тайланд 99,337.7 мянган төгрөгийн авлага, 4,106.7 мянган төгрөгийн өглөгтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Авлага өглөгийг барагдуулж, тооцоо нийлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн

7. Жинст багийн Хөгжил хорооллын халаалтын шугамын засварын төлбөрт 81 айл өрхөд 39,690.0 төгрөгийг дэмжлэг олгосон Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"-гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Төсвийг үр ашигтай, арилан хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

8. Эрүүл хот чадавхжуулах ТББ -аас ирүүлсэн урилгын дагуу БНСУ-д дэлхийн хотын чуулга уулзалтад оролцоход 11,500.0 мянган төгрөгийг, хотын дарга нар чуулга уулзалтад оролцоход 5,847.1 мянган төгрөгийг замын зардал, гадаад албан томилолт төсвөөс зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

9. Тушаал шийдвэргүйгээр 4,326.0 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2.2-т "төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид", 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, арилан хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Зардалтай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Цалингийн зардлын дүн нийгмийн даатгалын тайлангийн дүнгээс 2,147.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"; Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 хуулийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх"; гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын хэлтэстэй тооцоо нийлж зөрүүг арилгах арга хэмжээ авч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцоо а/ш	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газар	Амралын цалинг давхардуулан 1,350.1 мянган төгрөгийг илүү тооцон олгосон,	1	1,350.0	1	1,350.0	-	-	-	-	-	-
	Босго үнээс давсан 183,501.4 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй,	1	183,501.4	-	-	1	183,501.4	-	-	-	-
	Байгууллагын дансанд бүртгэлтэй 620.0 толгой малаас 2 иргэнтэй холбоотой 50 толгой 4,700.0 мянган төгрөгийн мал нь бодитоор байхгүй.	1	4,700.0	1	4,700.0	-	-	-	-	-	-
	Байгууллагын албан хаагчдад цалингийн төсвөөс хэмнэгдсэн 59,129.0 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүйгээр урамшуулал хэлбэрээр олгосон,	1	59,129.0	-	-	1	59,129.0	-	-	-	-
	Цалингийн зардлын дүн нийгмийн даатгалын тайлангийн дүнгээс 2,147.2 мянган төгрөгөөр зөрүүтэй,	1	2,174.2	-	-	-	-	1	2,147.2	-	-
	Тушаал шийдвэргүйгээр 4,326.0 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон,	1	4,326.0	-	-	1	4,326.0	-	-	-	-
	Үр дүнгийн урамшууллыг 2 ажилтанд 382.0 мянган төгрөгийг дутуу тооцож олгосон	1	382.0	1	382.0	-	-	-	-	-	-



Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хөрөнгийн хэсэгчилсэн тооллогоор байгууллагын дансанд бүртгэлтэй 521 ширхэг 477,636.4 мянган төгрөгийн хөрөнгийг бусад байгууллагад ашиглуулсан,	1	477,636.4	-	-	1	477,636.4	-	-	-	-
Цалингийн зардлын төсвөөс 1,164.8 мянган төгрөгийн шагнал олгосон,	1	1,164.8	-	-	1	1,164.8	-	-	-	-
Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын аварга малчдын бэлэг дурсгал шагналд 18,609.5 мянган төгрөгийг, хамт олон иргэн байгууллагад 34,182.9 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн, сургалт хоолны зардал 36,725.0 мянган төгрөгийг, уралдаан тэмцээний зардалд 8,204.0 мянган төгрөгийг зарцуулсан, золголтын зардал 600.0 мянган төгрөг, спортын ажилт гаргасан иргэн 5000.0 мянган төгрөг	1	105,321.4	-	-	1	105,321.4	-	-	-	-
Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд гадаад туршлага судлахад 15,000.0 мянган төгрөг, сумын хурлын төлөөлөгч нарт урамшуулал гарын бэлэг дурсгалын зүйлд 8,890.0 мянган төгрөг, баяр наадам зардалд 2,089.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	25,979.8	1	25,979.8	-	-	-	-	-	-
Эрүүл хот чадавжуулах ТББ -аас ирүүлсэн урилгын дагуу БНСУ-д дэлхийн хотын чуулга уулзалтад оролцоход 11,500.0 мянган төгрөгийг, хотын дарга нар чуулга уулзалтад оролцоход 5,847.1 мянган төгрөгийг замын зардал, гадаад албан томилолт төсвөөс зарцуулсан	1	17,347.1			1	17,347.1	-	-	-	-
Санхүүгийн тайланд 99,337.7 мянган төгрөгийн авлага, 4,106.7 мянган төгрөгийн өглөгтэй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-
Жинст багийн Хөгжил хорооллын халаалтын шугамын засварын төлбөрт 81 айл өрхөд 39,690.0 төгрөгийг дэмжлэг олгосон байна.	1	--	-	-	1	39,690.0	-	-	-	-
<b>Нийт</b>	<b>14</b>	<b>922,675.2</b>	<b>4</b>	<b>32,411.9</b>	<b>9</b>	<b>888,116.1</b>	<b>1</b>	<b>2,147.2</b>	<b>-</b>	<b>-</b>

Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал  
/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Есөнбулаг сумын ЗДТГ	Шилэн дансанд байршуулах таван сая төгрөгөөр дээш үнийн дүн бүхий зарлагын 3,718,639.4 мянган төгрөгийн 56 мэдээллээс , 238,058.8 мянган төгрөгийн 11 мэдээлэл мэдээлээгүй, төсөв өмч хөрөнгө зарцуулах 33 мэдээллээс 32 мэдээлээгүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-
<b>Нийт</b>		<b>1</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**7. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	<b>НИЙТ</b>		<b>1</b>				<b>1</b>		